


ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023.12.28

Улаанбаатар хот

Д/д	Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлууд	Хэрэгжилт	Биелэлтийн хувь
А	1	2	3
1.	Хугацаатай тайлан мэдээнд тавих хяналт /Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан журмын хавсралт/	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газраас дээд шатны байгууллагад тайлагнах хугацаатай тайлан мэдээний батлагдсан хуваарийн дагуу мөрдөж байна. 	100%
2.	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэр, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасны дагуу Хан-Уул дүүрэгт хэрэгжиж буй тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд эхний улиралд 18 тогтоол, шийдвэрийн 30 заалтын 56%, хагас жилд 30 тогтоол, шийдвэрийн 68 заалт 72%, гуравдугаар улиралд 19 шийдвэрийн 30 заалт 96.4%, 59 тогтоол, шийдвэрийн 132 заалтын хэрэгжилтэд, 92.3% бүрэн хэрэгжсэн, бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын илтгэх хуудсыг дүүргийн удирдлагад танилцуулж, дүгнэлт, зөвлөмжийг Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 06/571, 03/1135 тоот албан бичгээр холбогдох 24 байгууллагад хүргүүлсэн.	100%
3.	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс тус дүүргийн хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө биелэлт, Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайлан	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс тус дүүрэг хамтран хэрэгжүүлэх 2 бүлэг, 3 зорилт, 5 арга хэмжээ 98%, хяналт шинжилгээ, үнэлгээний 2 шалгуур үзүүлэлт 95%, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны төлөвлөгөөний 1 бүлэг, 2 зорилт, 4 арга хэмжээ 97,5%, хяналт шинжилгээ, үнэлгээний 1 шалгуур үзүүлэлт 100% үр дүнтэй, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 1 бүлэг, 1 зорилт, 4 арга хэмжээ жилийн эцэст 92%, хяналт шинжилгээ, үнэлгээний 5 шалгуур үзүүлэлт 90%, г.доторхой үр дүнд хүрсэн биелэлтийг хяналт шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайлангуудын хамт удирдлагад танилцуулан нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд сар бүр цахимаар илтээж, тайлагнасан.	100%

A	1	2	3
4.	<p>Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс тус дүүргийн хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайлан</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний 5 бүлэг, 9 зорилго, 22 зорилт, 47 арга хэмжээ жилийн эцэст 94%, хяналт шинжилгээ, үнэлгээний 3 бүлгийн 36 шалгуур үзүүлэлт жилийн эцэст 91%, Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 1 бүлэг, 3 зорилго, 3 зорилтын 3 арга хэмжээ жилийн эцэст 90%, хяналт-шинжилгээ, үнэлгээний 3 шалгуур үзүүлэлт жилийн эцэст 90%, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 4 бүлэг, 15 зорилго, 16 зорилт, 81 арга хэмжээ жилийн эцэст 90% тодорхой үр дүнд хүрсэн. Улирал тутам нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, тайлагнасан.</p>	100%
5.	<p>Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайлан</p>	<p>Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл Дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 23 зорилго, 108 зорилт, 151 арга хэмжээ эхний улирлын байдлаар 31%, хагас жилд 54%, гуравдугаар улиралд 72%, жилийн эцэст 90.4%, хяналт шинжилгээ, үнэлгээний 164 шалгуур үзүүлэлт 90% тодорхой үр дүнд хүрсэн бөгөөд дүүргийн Засаг даргын зөвлөлийн хуралд тухай бүр танилцуулсан.</p>	100%
6.	<p>Засаг даргын Тамгын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p>	<p>Засаг даргын Тамгын газрын 2023 оны гүйцэтгэлийн тайлангийн 5 бүлэг, 68 зорилт, 180 арга хэмжээний 1 дүгээр улирлын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 47.8%, хагас жилд 56.2%, жилийн эцэст 95.6% тодорхой үр дүнд хүрсэн. Тайлант хугацаанд хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын 2023/05 дугаар зөвлөмжийг холбогдох хэлтсүүдэд хүргүүлсэн.</p>	100%
7.	<p>Хан-Уул дүүрэгт ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт</p>	<p>Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн эхний тайланд сар, улирал тутам хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөрчил гомдлыг бууруулах чиглэлээр давхардсан тоогоор дүүргийн Засаг даргын харьяа давхардсан тоогоор 88 байгууллагад Тамгын газрын 2023 оны 06/82, 06/382-388, 06/571 тоот албан бичгээр хүргүүлж, биелэлтийг тооцон ажиглаж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал дүүрэгт бүртгэгдсэн өргөдөл 11%-иар өссөн хэдий ч өргөдөлд эзлэх гомдлын тоо 43,9-өөс 40,8%, зөрчлийн тоо 34,5%-аас 22,7% болж тус тус буурсан.</p>	100%
8.	<p>Дүүргийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны явц, гүйцэтгэлд</p>	<p>Дүүргийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, хэрэгжиж буй бодлогын баримт бичгийн 2023 оны хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, 2023/06 дугаар зөвлөмжийг 03/1135 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p>	

А	1	2	3
9.		Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон өргөдөл гомдол шийдвэрлэлтийн зөрчлийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн явцад хийх хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын удирдамжийг 2023 оны 05 дугаар сарын 01, 10 дугаар сарын 01-нд 2 удаа Засаг даргын Тамгын газрын даргаар багтүүлж, хуваарийн дагуу Хяналт шалгалтын болон зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Жилийн эцсийн гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын удирдамжийг дүүргийн Засаг даргын 2023 оны А/688 дугаар захирамжаар багтүүлж, хуваарийн дагуу ХИ/05-ХИ/20-ны хооронд зохион байгуулж, дүнг дүүргийн Засаг даргын зөвлөлийн хуралд 12 дугаар сарын 20-нд танилцуулсан.	100%
10.	Дүүргийн Засаг даргын Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх Хармуцлагын гэрээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	Дүүргийн Засаг даргын 2023 оны хармуцлагын гэрээний 2 бүлэг 43 зорилт, 73 арга хэмжээ эхний улиралд 36%, хагас жилд 55,5%, гуравдугаар улиралд 78%, жилийн эцэст 93% хэрэгжсэн. Хармуцлагын гэрээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд 2023/05 дугаар зөвлөмжийг хүргүүлсэн.	100%
11.	Бодлогын баримт бичигт хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, илтгэх хуудсыг дүүргийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж тайлагнах	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлт зөвлөмжийг дүүргийн удирдлагад тухай бүр танилцуулсны дагуу албан бичгээр болон шуурхай зөвлөгөөнөөр тус тус хэрэгжилтийг эрчимжүүлэх үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг тооцон холбогдох байгууллага албан тушаалтанд улирал, сар тутам тайлагнасан.	100%
12.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, хүргүүлэх	2023 онд бодлогын баримт бичгийн хэрэгжилт, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцад хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын 6 зөвлөмжийг давхардсан тоогоор дүүргийн Засаг даргын харьяа давхардсан тоогоор 88 байгууллагад Тамгын газрын 2023 оны 06/82, 06/382-388, 06/571, 03/1135 тоот албан бичгээр хүргүүлж, биелэлтийг тооцон ажигласан.	100%
13.	Өргөдөл гомдол, албан бичгийн шийдвэрлэлтэд зөрчил тооцогдсон байгууллагуудад түүвэрлэж ХШҮ хийх	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон өргөдөл гомдол шийдвэрлэлтийн зөрчлийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн явцад хийх хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын удирдамжийг 2023 оны 05 дугаар сарын 01, 10 дугаар сарын 01-нд 2 удаа Засаг даргын Тамгын газрын даргаар багтүүлж, хуваарийн дагуу Хяналт шалгалтын болон зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан.	100%

A	1	2	3
14. Бусад /Цаг үеийн шаардлагаар хийгдэх хяналт шинжилгээ, үнэлгээ/		<p>Дүүргийн Засаг даргын 2023 оны А/625 дугаар захирамжаар Ажлын хэсгийн нарийн бичгээр томилогдон ажлын хэсгүүдийг ажлын төлөвлөгөө, хуваарийг батлуулан 2023 оны 11 дүгээр сарын 13-16ны өдрүүдэд дүүрэгт байрладаг 34 нийтийн байрны барилга байгууламж, орчны аюулгүй байдалд холбогдох мэргэжлийн улсын байцаагчдын хамт хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан бөгөөд нийт 34 байрнаас үйл ажиллагаа нь зогссон 8, шинээр үйл ажиллагаа явуулж байгаа 5 нийтийн байр байсан бөгөөд нийт 31 нийтийн байрны талаарх тоон мэдээлэл, баримт, илтгэх хуудас болон улсын байцаагч нарын илтгэх хуудас, танилцуулгын хамт Засаг даргын Тамгын газрын 2023 оны 03/1899 дүгээр албан бичгээр УБ хотын ЗМД-нд хургуулсан.</p> <p>БИЕЛЭЛТ</p>	100%
			100%

ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

С.ЭНХБАЯР

ХЯНАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
 ҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
 П.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
 МЭРГЭЖИЛТЭН
 Н.АТДАРМАА

